



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2024 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/27/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Ахлах аудитор С.Санжаажав

Утас: 70373089 Цахим хаяг: sanjaajavs@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2025 он

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5-12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14-16
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА Л.БАЯРНЯМ
ТАНАА

2025.02.11 № ДАА-2025/27/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийгмийн даатгалын ерөнхий хууль 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, Засгийн газрын 2023 оны 469 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”-д заасны дагуу Нийгмийн даатгалын газар нэртэйгээр өөрчлөн зохион байгуулж, үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж эхэлсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд газрын хамт олны бичсэн “Ухаалаг самбар” төсөл дэмжигдсэнээр аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас 19,980.0 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан авч, зориулалтын дагуу бүрэн зарцуулжээ.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 49 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилт 93.3 хувиар дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	50,792,990.37	71,743,480.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,419.82	71,743,480.20
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	5,419.82	-
31210	Төгрөг	-	-
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	5,419.82	-
35	БАРАА МАТЕРИАЛ	50,787,570.55	71,743,480.20
35400	Хангамжийн материал	50,787,570.55	71,743,480.20
35410	Бичиг хэргийн материал	1,557,500.00	986,850.00
35420	Аж ахуйн материал	30,966,757.14	34,021,297.14
35430	Сэлбэг хэрэгсэл	15,499,025.00	32,361,325.00
35440	Түлш, шатах тослох материал	-	540,000.00
35450	Барилгын засварын материал	-	1,912,450.00
35470	Бусад хангамжийн материал	2,764,288.41	1,921,558.06
3695	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,679,623,899.74	1,663,032,536.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,679,623,899.74	1,663,032,536.10
39200	Биет хөрөнгө	1,598,607,556.23	1,582,349,267.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,713,895,113.20	1,726,872,113.20
39202	Хуримтлагдсан элэгдэл	(215,708,233.89)	(246,785,500.21)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	12,210,000.00	12,210,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(4,884,000.00)	(7,326,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	119,585,768.28	139,565,768.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	(51,841,145.81)	(69,403,779.17)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	102,480,034.25	112,480,034.25
39208	Хуримтлагдсан элэгдэл	(77,129,979.80)	(85,263,368.64)
39300	Биет бус хөрөнгө	81,016,343.51	80,683,268.39
39301	Програм хангамж	7,426,706.00	7,426,706.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(7,010,362.49)	(7,343,437.61)
39303	Бусад биет бус хөрөнгө	80,600,000.00	80,600,000.00
395	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,730,416,890.11	1,734,776,016.30
50	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,730,416,890.11	1,734,776,016.30
51	Засгийн газрын хувь оролцоо	1,730,416,890.11	1,734,776,016.30
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	410,560,290.27	410,560,290.27
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	410,560,290.27	410,560,290.27
51200	Хуримтлагдсан үр дүн	1,297,054,920.59	1,301,414,046.78
51210	Өмнөх үеийн үр дүн	1,315,795,423.95	1,307,132,972.99
51220	Тайлант үеийн үр дүн	(18,740,503.36)	(5,718,926.21)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	22,801,679.25	22,801,679.25
60	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,730,416,890.11	1,734,776,016.30

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,338,631,193.24	2,001,962,300.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,472,545.60	14,196,000.00
Нийтлэг татварын бус орлого	9,472,545.60	14,196,000.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	9,472,545.60	14,196,000.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	9,472,545.60	12,977,000.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	1,219,000.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,329,158,647.64	1,987,766,300.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	101,577,429.00	268,778,500.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	101,577,429.00	-
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	268,778,500.00
Төсвийн захирагчдаас	11,736,018.64	1,718,987,800.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,718,987,800.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	11,736,018.64	-
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,215,845,200.00	-
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,215,845,200.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,357,371,696.60	2,007,681,226.21
УРСГАЛ ЗАРДАЛ	1,357,371,696.60	2,007,681,226.21
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,253,724,026.22	1,798,342,997.64
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	980,000,495.21	1,482,460,453.90
Үндсэн цалин	535,568,178.09	739,426,100.42
Нэмэгдэл	288,022,688.06	534,610,985.00
Унаа хоолны хөнгөлөлт	51,090,067.58	70,081,000.00
Урамшуулал	105,319,561.48	138,342,368.48
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,373,939.41	180,972,860.79
Тэтгэврийн даатгал	84,570,310.67	124,659,333.91
Тэтгэмжийн даатгал	9,949,447.93	14,142,280.30
ҮОМШӨ-ний даатгал	7,809,958.23	7,070,590.41
Ажилгүйдлийн даатгал	1,686,168.84	6,866,877.26
Эрүүл мэндийн даатгал	17,358,053.74	28,233,778.91
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,420,169.72	20,711,781.56
Гэрэл, цахилгаан	7,673,311.24	7,750,002.06
Түлш, халаалт	9,270,504.92	10,742,040.78
Цэвэр, бохир ус	2,476,353.56	2,219,738.72
Хангамж, бараа материалын зардал	20,925,854.99	16,389,944.00
Бичиг хэрэг	13,491,900.00	9,015,850.00
Тээвэр, шатахуун	1,230,000.00	2,210,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,841,662.49	1,761,774.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000.00	760,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,544,730.00	2,192,320.00
Бараа материал акталсны зардал	117,562.50	450,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	8,059,450.00	4,432,500.00

Багаж, техник, хэрэгсэл	117,200.00	646,000.00
Урсгал засвар	7,942,250.00	3,786,500.00
Томилолт, зочны зардал	8,710,900.00	9,619,600.00
Дотоод албан томилолт	8,710,900.00	9,619,600.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,712,605.68	11,349,441.35
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,430,400.00	540,000.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,400,000.00	4,690,000.00
Даатгалын үйлчилгээ	3,500,000.00	3,900,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	84,011.00	72,511.00
Газрын төлбөр	161,200.00	161,200.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	475,000.00	466,000.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	661,994.68	1,519,730.35
Бараа үйлчилгээний бусад зардал	80,520,611.21	72,406,416.04
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,899,700.00	2,780,000.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	62,620,911.21	69,626,416.04
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	103,647,670.38	209,338,228.57
Бусад урсгал шилжүүлэг	5,836,000.00	156,841,972.50
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,836,000.00	13,304,000.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	143,537,972.50
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	52,496,256.07
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	51,294,762.39
Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,201,493.68
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	97,811,670.38	-
Төвлөрүүлэх шилжүүлэг	97,811,670.38	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (I)-(II)	(18,740,503.36)	(5,718,926.21)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(18,740,503.36)	(5,718,926.21)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	1,317,422,629.00	1,987,766,300.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,317,422,629.00	1,987,766,300.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	101,577,429.00	268,778,500.00
ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	101,577,429.00	-
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	268,778,500.00
Төсвийн захирагчдаас	-	1,718,987,800.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,718,987,800.00
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,215,845,200.00	-
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,215,845,200.00	-
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,317,422,629.00	1,957,791,719.82
УРСГАЛ ЗАРДАЛ	1,317,422,629.00	1,957,791,719.82
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,218,724,958.62	1,748,453,491.25
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	980,000,496.00	1,482,460,453.90
Үндсэн цалин	535,854,959.09	739,426,100.42
Нэмэгдэл	288,022,688.06	534,610,985.00
Унаа хоолны хөнгөлөлт	51,090,067.58	70,081,000.00
Урамшуулал	105,032,781.27	138,342,368.48
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,255,079.41	180,972,860.79
Тэтгэврийн даатгал	84,463,210.67	124,659,333.91
Тэтгэмжийн даатгал	9,949,447.93	14,142,280.30
ҮОМШӨ-ний даатгал	7,799,878.23	7,070,590.41
Ажилгүйдлийн даатгал	1,684,488.84	6,866,877.26
Эрүүл мэндийн даатгал	17,358,053.74	28,233,778.91
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,420,169.72	20,711,781.56
Гэрэл, цахилгаан	7,673,311.24	7,750,002.06
Түлш, халаалт	9,270,504.92	10,742,040.78
Цэвэр, бохир ус	2,476,353.56	2,219,738.72
Хангамж, бараа материалын зардал	38,124,642.49	18,421,834.00
Бичиг хэрэг	10,985,500.00	8,445,200.00
Тээвэр, шатахуун	1,230,000.00	2,750,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,841,662.49	1,761,774.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000.00	760,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,367,480.00	4,704,860.00
Эд хогшил, урсгал засварын зардал	18,978,500.00	23,657,250.00
Багаж, техник, хэрэгсэл	11,036,250.00	17,958,300.00
Урсгал засвар	7,942,250.00	5,698,950.00
Томилолт, зочны зардал	8,710,900.00	9,619,600.00
Дотоод албан томилолт	8,710,900.00	9,619,600.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,216,611.00	9,829,711.00

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,596,400.00	540,000.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,400,000.00	4,690,000.00
Даатгалын үйлчилгээ	3,500,000.00	3,900,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	84,011.00	72,511.00
Газрын төлбөр	161,200.00	161,200.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	475,000.00	466,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	17,899,700.00	2,780,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,899,700.00	2,780,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,546,183.38	209,338,228.57
Бусад урсгал шилжүүлэг	5,836,000.00	156,841,972.50
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,836,000.00	13,304,000.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	143,537,972.50
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	52,496,256.07
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	51,294,762.39
Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,201,493.68
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	92,861,670.38	-
Төвлөрүүлэх шилжүүлэг	92,861,670.38	-
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	29,974,580.18
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ	-	29,980,000.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	29,980,000.00
Дотоод эх үүсвэрээр	-	29,980,000.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	29,980,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(29,980,000.00)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(5,419.82)
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,419.82	5,419.82
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,419.82	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 01-р сарын 01-нээрс эхний үлдэгдэл	410,560,290.27	22,801,679.25	1,315,795,423.95	1,749,157,393.47
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	410,560,290.27	22,801,679.25	1,315,795,423.95	1,749,157,393.47
Тайлант үеийн үр дүн	-	-	(18,740,503.36)	(18,740,503.36)
2023 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	410,560,290.27	22,801,679.25	1,297,054,920.59	1,730,416,890.11
2024 оны 01-р сарын 01-нээрс эхний үлдэгдэл	410,560,290.27	22,801,679.25	1,297,054,920.59	1,730,416,890.11
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	10,078,052.40	10,078,052.40
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	410,560,290.27	22,801,679.25	1,307,132,972.99	1,740,494,942.51
Тайлант үеийн үр дүн	-	-	(5,718,926.21)	(5,718,926.21)
2024 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	410,560,290.27	22,801,679.25	1,301,414,046.78	1,734,776,016.30

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,718,987,800.00	1,667,693,037.61	(51,294,762.39)	97.0
УРСГАЛ ЗАРДАЛ	1,718,987,800.00	1,667,693,037.61	(51,294,762.39)	97.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,562,088,900.00	1,510,856,484.93	(51,232,415.07)	96.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,298,380,200.00	1,262,005,436.90	(36,374,763.10)	97.2
Үндсэн цалин	752,931,000.00	739,426,100.42	(13,504,899.58)	98.2
Нэмэгдэл	312,389,900.00	314,155,968.00	1,766,068.00	100.6
Унаа хоолны хөнгөлөлт	84,070,800.00	70,081,000.00	(13,989,800.00)	83.4
Урамшуулал	148,988,500.00	138,342,368.48	(10,646,131.52)	92.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	156,450,600.00	154,070,871.47	(2,379,728.53)	98.5
Тэтгэврийн даатгал	106,835,700.00	105,920,657.50	(915,042.50)	99.1
Тэтгэмжийн даатгал	12,403,700.00	11,937,730.13	(465,969.87)	96.2
ҮОМШӨ-ний даатгал	6,201,800.00	5,968,315.36	(233,484.64)	96.2
Ажилгүйдлийн даатгал	6,201,800.00	5,895,579.70	(306,220.30)	95.1
Эрүүл мэндийн даатгал	24,807,600.00	24,348,588.78	(459,011.22)	98.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,037,800.00	20,711,781.56	(8,326,018.44)	71.3
Гэрэл, цахилгаан	10,178,700.00	7,750,002.06	(2,428,697.94)	76.1
Түлш, халаалт	15,887,900.00	10,742,040.78	(5,145,859.22)	67.6
Цэвэр, бохир ус	2,971,200.00	2,219,738.72	(751,461.28)	74.7
Хангамж, бараа материалын зардал	20,119,000.00	18,421,834.00	(1,697,166.00)	91.6
Бичиг хэрэг	8,456,000.00	8,445,200.00	(10,800.00)	99.9
Тээвэр, шатахуун	3,500,000.00	2,750,000.00	(750,000.00)	78.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,673,100.00	1,761,774.00	(911,326.00)	65.9
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	760,000.00	760,000.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,729,900.00	4,704,860.00	(25,040.00)	99.5
Эд хогшил, урсгал засварын зардал	33,837,100.00	33,657,250.00	(179,850.00)	99.5
Багаж, техник, хэрэгсэл	28,137,100.00	27,958,300.00	(178,800.00)	99.4
Урсгал засвар	5,700,000.00	5,698,950.00	(1,050.00)	100.0
Томилолт, зочны зардал	9,416,100.00	9,379,600.00	(36,500.00)	99.6
Дотоод албан томилолт	9,416,100.00	9,379,600.00	(36,500.00)	99.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,052,300.00	9,829,711.00	(2,222,589.00)	81.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,688,600.00	540,000.00	(2,148,600.00)	20.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,708,800.00	4,690,000.00	(18,800.00)	99.6
Даатгалын үйлчилгээ	3,924,000.00	3,900,000.00	(24,000.00)	99.4
Тээврийн хэрэгслийн татвар	98,100.00	72,511.00	(25,589.00)	73.9
Газрын төлбөр	166,800.00	161,200.00	(5,600.00)	96.6
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	466,000.00	466,000.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	2,795,800.00	2,780,000.00	(15,800.00)	99.4

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,795,800.00	2,780,000.00	(15,800.00)	99.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	156,898,900.00	156,836,552.68	(62,347.32)	100.0
Бусад урсгал шилжүүлэг	156,898,900.00	156,836,552.68	(62,347.32)	100.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	13,360,300.00	13,298,580.18	(61,719.82)	99.5
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	143,538,600.00	143,537,972.50	(627.50)	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,718,987,800.00	1,667,693,037.61	(51,294,762.39)	97.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,718,987,800.00	1,667,693,037.61	(51,294,762.39)	97.0
Улсын төсвөөс санхүүжих	1,718,987,800.00	1,667,693,037.61	(51,294,762.39)	97.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	267,577,006.32
УРСГАЛ ЗАРДАЛ	267,577,006.32
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	267,577,006.32
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	220,455,017.00
Нэмэгдэл	220,455,017.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,901,989.32
Тэтгэврийн даатгал	18,738,676.41
Тэтгэмжийн даатгал	2,204,550.17
ҮОМШӨ-ний даатгал	1,102,275.05
Ажилгүйдлийн даатгал	971,297.56
Эрүүл мэндийн даатгал	3,885,190.13
Томилолт, зочны зардал	240,000.00
Дотоод албан томилолт	240,000.00
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	19,980,000.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,980,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	267,577,006.32
Нэмэлт санхүүжилтийн орлого	267,577,006.32
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	267,577,006.32

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын газар нь Нийгмийн даатгалын багц хуулиудыг хэрэгжүүлэх, сурталчлах, хамралтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хуульд заасан хугацаанд тогтоон олгох чиг үүргийг хэрэгжүүлдэг НДЕГ-ын харьяа байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль эрхийн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчлэн найруулсан хууль мөрдөгдөж, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна. Төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,359.1 мянган төгрөгөөр буюу 0.2 хувиар өссөн байна. Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5.4	-	(5.4)
Бараа материал	50,787.6	71,743.5	20,955.9
Үндсэн хөрөнгө	1,679,623.9	1,663,032.5	(16,591.4)
Нийт хөрөнгө	1,730,416.9	1,734,776.0	4,359.1
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,730,416.9	1,734,776.0	4,359.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,730,416.9	1,734,776.0	4,359.1

Мөнгөн хөрөнгө данс 5.4 мянган төгрөгөөр буурсан нь ахмадын сангийн зарцуулагдаагүй үлдэгдлийг оны эцэст төсөвт буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 38,813.3 мянган төгрөгийн бараа материал бэлтгэсэн, НДЕГ-аас 1,219.0 мянган төгрөгийн аж ахуйн болон бусад хангамжийн материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан, 19,076.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан зэргээс шалтгаалж, бараа материалын үлдэгдэл оны эцэст өссөн байна.

Үндсэн хөрөнгө 16,591.4 мянган төгрөгөөр буурахад хуримтлагдсан элэгдлийн өсөлт голлон нөлөөлжээ. Тодруулбал тайлант онд төсвийн хөрөнгөөр 10,000.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 19,980.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авсан, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон аймгийн Орон нутгийн өмчийн газрын хамтарсан шалгалтаар өгсөн чиглэлийн дагуу нийтийн эзэмшлийн зам талбайг 12,977.0 мянган төгрөгөөр үнэлж бүртгэсэн, 69,626.4 мянган төгрөгийн элэгдэл тооцсон зэргээс шалтгаалжээ.

Засгийн газрын хувь оролцоо данс 4,359.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн болон өнгөрсөн онд илүү тооцсон элэгдлийн зардал 10,078.1 мянган төгрөгийг залруулж бүртгэсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд 1,661,699.8 мянган төгрөгийн зардлыг 100 хувь улсын төсвийн эх үүсвэрээр бүрдүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ. Төсвийн төслийн саналаас 236,201.9 мянган төгрөгийг хасаж, 1,425,497.9 мянган төгрөгөөр баталсан байна. Тодруулбал цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 277,882.5 мянган төгрөгөөр, байр ашиглалтын зардлыг 1,142.4 мянган төгрөгөөр, хангамж, бараа материал, эд хогшил, урсгал засварын зардлыг 8,205.3 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 2,085.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс, төлбөр хураамжийн зардлыг 17,151.3 мянга, урсгал шилжүүлгийг 25,787.1 мянган төгрөгөөр тус тус бууруулж, бараа үйлчилгээний бусад зардлыг 8,955.9 мянган төгрөгөөр нэмж баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд батлагдсан төсвийг 293,489.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Үүнд: Засгийн газрын тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлсэн тул цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 229,513.5 мянган төгрөгөөр, байр ашиглалтын зардлыг 155.2 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 3,400.0 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 4,511.1 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 2,688.6 мянган төгрөгөөр, Төрийн захиргааны албан хаагчид 5 жилийн тэтгэмж олгож эхэлснээр урсгал шилжүүлгийг 119,870.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, бараа үйлчилгээний бусад зардлыг 12,805.9 мянган төгрөгөөр бууруулсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэх 1,718,987.8 мянган төгрөгийг 100 хувь улсын төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч, зарлагын гүйцэтгэл 1,667,693.0 мянган төгрөг буюу 97.0 хувьтай гарч, зарцуулаагүй үлдсэн 51,294.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Энэ нь дутуу орон тоогоор ажилласан тул цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 61,830.2 мянган төгрөгөөр, төсвийн төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөгөөгүйгээс байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 8,326.0 мянган төгрөгөөр тус тус зарцуулаагүйгээс шалтгаалжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71901-Нийгмийн даатгал	1,718,987.80	1,667,693.03	51,294.77	97.0
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	1,471,547.80	1,435,083.62	36,464.18	97.5
1.2	80103-гэрээгээр гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	4,455.00	3,154.80	1,300.20	70.8
1.3	80205-Мэдээлэл, сурталчилгааны зардал	-	-	-	-
1.4	80213-Өмгөөлөл хуулийн зөвлөхийн үйлчилгээний хөлс	188.60	140.00	48.60	74.2
1.5	80219-Харуул хамгаалалтын зардал	-	-	-	-
1.6	80224-Зөвлөл, хороо гишүүдийн ажлын хөлс	85,897.50	72,478.06	13,419.44	84.4
1.7	80802-Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	143,538.60	143,537.97	0.63	100.0
1.8	80813-Хуульд заасан үндэслэлээр албан хаагчид олгох нөхөн олговор	2,256.30	2,250.00	6.30	99.7
1.9	80820-Бусад тусламж дэмжлэг	11,104.00	11,048.58	55.42	99.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд улсын болон орон нутгийн төсвөөс 268,778.5 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулж, зарцуулагдаагүй үлдсэн 1,201.5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Тодруулбал: орон нутгийн төсвөөс төрийн албан хаагчид олгох орон нутгийн нэмэгдэл цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 248,558.5 мянган төгрөгийн, “Ухаалаг самбар” төслийн санхүүжилтээр 19,980.0 мянган төгрөгийн, НДЕГ-аас дотоод албан томилолтын зардалд 240.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн нэмэгдэл цалингаас зарцуулаагүй үлдсэн 1,201.5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл:

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Санжаажав гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 37 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсвийн 1,706,987.8.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 17,069.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд батлагдсан төсвийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд үр ашигтай зарцуулсан байна.


Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт

Өмнөх аудитаар нийгмийн даатгалын сангаас иргэнд илүү тооцож олгосон 2,139.6 мянган төгрөгийг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоосныг хугацаанд нь бүрэн барагдуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.



4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй бөгөөд мэдээллийг бүрэн байршуулсан байв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 2,139.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулж, төсвийг хохиролгүй болгосон байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт


Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	2,139.6	2	2,139.6	100
Нийт дүн	1	2,139.6	1	2,139.6	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 2,300.5 мянган төгрөгийн зөрчилд¹ албан шаардлага хүргүүллээ.



5.1 Төлбөрийн акт

- Төлбөрийн акт тавих зөрчил илрээгүй болно.

5.2 Албан шаардлага

- Байгууллагын санхүүгийн ажилтнуудад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалттай давхардуулан 2,300.5 мянган төгрөгийн балансын урамшуулал олгож төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно, 15.1.3: "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

5.3 Зөвлөмж²

Зөвлөмж өгөх зөрчил илрээгүй болно.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² 20.5.Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс										Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал
		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Албан тушаалтны тоо		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
		/мянган төгрөгөөр/										
Тайлант онд санхүүгийн жилтнүүдэд улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалттай давхардуулан балансын урамшуулал олгосон.	1	2,300.5	-	1	2,300.5	-	-	-	-	-	-	-
Дүн	1	2,300.5	-	1	2,300.5	-	-	-	-	-	-	-